



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 463

Улаанбаатар хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйл, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын “Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай” 2022 оны 326 дугаар тогтоолын хавсралтын 10 дугаарт Эрүүл мэндийн яамны Ланд круйзер 200 маркийн 0553 УБЗ улсын дугаартай автомашины балансын үнэ 37,500,000.00 (гучин долоон сая таван зуун мянга) төгрөг гэснийг 93,000,000.00 (ерэн гурван сая), хуримтлагдсан элэгдэл 14,843,750.00 (арван дөрвөн сая найман зуун дөчин гурван мянга долоон зуун тавин) төгрөг гэснийг 93,000,000.00 (ерэн гурван сая), үлдэх өртөг 22,656,250.00 (хорин хоёр сая зургаан зуун тавин зургаан мянга хоёр зуун тавин) төгрөг гэснийг 0.00 (тэг) гэж тус тус өөрчилсүгэй.

2.Эрүүл мэндийн яамнаас “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газарт шилжүүлсэн Ланд круйзер 200 маркийн 0553 УБЗ улсын дугаартай автомашины ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, үнийг 22,656,250.00 (хорин хоёр сая зургаан зуун тавин зургаан мянга хоёр зуун тавин) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.

3.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газрын дарга С.Төгсдэлгэр, “Засгийн газрын авто бааз” аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;

3.2.Хөрөнгө данснаас хасах, хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.4.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

3.5.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Д.НАРАНГЭРЭЛ

